



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 416

Улаанбаатар хот

Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард даатгал” ХК-ийн “Хадгаламжийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг шинээр нэгдүгээр хавсралтаар, “Автотээврийн хэрэгслийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг шинэчлэн хоёрдугаар хавсралтаар тус тус бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Ард даатгал” ХК /Г.Цогбадрах/-д үүрэг болгосугай.

3. Тус бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Ард даатгал” ХК /Г.Цогбадрах/-д анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 11-р сарын 27-өдрийн
416-р тогтоолын 1 дүгээр хавсралт



ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МЭДЭЭЛЭЛ

| | | |
|-----|--|--|
| 1. | Даатгалын компанийн нэр: | “Ард даатгал” ХК |
| 2. | Даатгалын бүтээгдэхүүний нэр: | Хадгаламжийн даатгал |
| 3. | Хамаарах даатгалын хэлбэр: | Санхүүгийн даатгал |
| 4. | Даатгалын зүйл | Даатгуулагчийн гишүүдийн хугацаатай хадгаламж |
| 5. | Даатгалын эрсдэл | Хорооны 2018 оны 6 сарын 29-ний өдрийн 245 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 9.1.3 болон 9.1.4-т заасны улмаас ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн 9.6.3 болон 9.6.6-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох |
| 6. | Даатгалын гэрээний хугацаа | Харилцан тохиролцоно |
| 7. | Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо | 10 бүлэг, 76 заалт |
| 8. | Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр: | “Ард даатгал” ХК-ийн гүйцэтгэх хорооны хурлын 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн шийдвэр. |
| 9. | Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч: | Г.Ариунжаргал |
| 10. | Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан: | Эрсдэлийн шинжээч Б.Нямдэлгэр, Г.Гантигмаа |

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 11-р сарын 27-өдрийн
416-р тогтоолын 1 дүгээр хавсралт



ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МЭДЭЭЛЭЛ

| | | |
|-----|--|--|
| 1. | Даатгалын компанийн нэр: | “Ард даатгал” ХК |
| 2. | Даатгалын бүтээгдэхүүний нэр: | Хадгаламжийн даатгал |
| 3. | Хамаарах даатгалын хэлбэр: | Санхүүгийн даатгал |
| 4. | Даатгалын зүйл | Даатгуулагчийн гишүүдийн хугацаатай хадгаламж |
| 5. | Даатгалын эрсдэл | Хорооны 2018 оны 6 сарын 29-ний өдрийн 245 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 9.1.3 болон 9.1.4-т заасны улмаас ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн 9.6.3 болон 9.6.6-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох |
| 6. | Даатгалын гэрээний хугацаа | Харилцан тохиролцоно |
| 7. | Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо | 10 бүлэг, 76 заалт |
| 8. | Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр: | “Ард даатгал” ХК-ийн гүйцэтгэх хорооны хурлын 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн шийдвэр. |
| 9. | Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч: | Г.Ариунжаргал |
| 10. | Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан: | Эрсдэлийн шинжээч Б.Нямдэлгэр, Г.Гантигмаа |

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 2-р сарын 27-дрийн
416-р тогтоолын 2 дугаар хавсралт

ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МЭДЭЭЛЭЛ

| | | |
|-----|--|--|
| 1. | Даатгалын компанийн нэр: | “Ард даатгал” ХК |
| 2. | Даатгалын бүтээгдэхүүний нэр: | Автотээврийн хэрэгслийн даатгал |
| 3. | Хамаарах даатгалын хэлбэр: | Автотээврийн хэрэгслийн даатгал |
| 4. | Даатгалын зүйл | Автотээврийн хэрэгсэл буюу даатгуулагчийн өмчлөл, эзэмшилд байгаа механикжсан тээврийн хэрэгслүүд болон замын хөдөлгөөний дүрмээр зөвшөөрөгдсөн нэмэлт тоноглол |
| 5. | Даатгалын эрсдэл | Хамгаалалтын нөхцөлөөс хамаарч эдгээр эрсдэлээс сонгоно. Үүнд: 1. Байгалийн эрсдэл; 2. Гал, бүх төрлийн тэсрэлт, дэлбэрэлт; 3. Зам тээврийн хөдөлгөөнд оролцох үеийн бүх осол; 4. Зам тээврийн хөдөлгөөнд оролцоогүй байх үеийн бүх осол; 5. Зориулалтын зогсоолд зогсож байх үед сантехникийн уснаас учирсан хохирол; 6. Зогсоолын эрсдэл (зогсож байх үед). Үүнд: Мөргүүлэх, шүргүүлэх, дээрээс биет зүйл унах, гуравдагч этгээдийн санаандгүй үйлдлээс учирсан хохирол; 7. Ослын бус үед зөвхөн салхины шил, цонхны шил хагарах, гэмтэх /жилд 2 удаа; 8. Жолоо шилжүүлэх үеийн; 9. Зайлшгүй тохиолдолд замгүй газраар явах, усан гармаар гарах үеийн эрсдэл; 10. Жолооч болон зорчигчийн гэнэтийн осол (жилдээ); 11. Эд ангийн хулгайн эрсдэл; 12. Их биеийн хулгайн эрсдэл; . Нэмэлт зардлын даатгал. |
| 6. | Даатгалын гэрээний хугацаа | 1 жил |
| 7. | Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо | 13 бүлэг, 174 заалт |
| 8. | Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр: | “Ард даатгал” ХК-ийн гүйцэтгэх хорооны хурлын 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн шийдвэр. |
| 9. | Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч: | Г.Ариунжаргал |
| 10. | Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан: | Эрсдэлийн шинжээч Б.Нямдэлгэр, Г.Гантигмаа |